



**ОРХОН АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ**

2017 оны 09 сарын 14 өдөр

Дугаар А/545

Эрдэнэт

Хөрөнгө гаргах тухай

Монгол улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.5 а, 29.2, Эрүүл мэндийн тухай хуулийн 11.1.2, 11.1.8, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын 2016 оны 10 дугаар сарын 28-ны өдрийн ээлжит III хуралдааны 01 дүгээр тогтоол, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2016 оны 12 дугаар сарын 02-ны өдрийн VI хуралдааны 02 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1."Орхон аймгийн Засаг даргын 2016-2020 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны хөтөлбөр болон түүнийг хэрэгжүүлэх төлөвлөгөө"-ны 1.1.11.1 заалтыг хэрэгжүүлэх ажлын хүрээнд "Элэгний вирусгүй хамт олон"-2 аяны тугийг албан байгууллага, аж ахуй нэгжээр аялуулж, "Элэгний вирусын шалтгаант өвчлөл", "Амьдралын буруу хэв дадал" сэдэвт сургалт явуулах арга хэмжээг "Эрдэнэтийн эрүүл иргэн" ТББ-тай 2017 оны 09 дүгээр сарын 15-ны өдрөөс 4 сарын хугацаанд хамтран зохион байгуулж, төрийн зарим үйлчилгээг гүйцэтгүүлсүгэй.

2.Шаардагдах зардал 2000000 /Хоёр сая/ төгрөгийг "Төрийн бус байгууллагуудтай хамтран ажиллах гэрээ байгуулах зардал"-аас гаргахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү төрийн сангийн хэлтэс /н. Бямбацэцэг/-т зөвшөөрсүгэй.


3.Батлагдсан хөрөнгийг зориулалтын дагуу зарцуулан, үр дүнг тайлагнаж ажиллахыг "Эрдэнэтийн эрүүл иргэн" ТББ-д, захирамжийн хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг Нийгмийн бодлогын хэлтэс /н.Бумансор/, Эрүүл мэндийн газар/н.Баттүвшин/-т тус тус даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Д.БАТЛУТ

Аймгийн Засаг даргын 2017 оны
09 дүгээр сарын 14-ны өдрийн
575 дугаар захирамжийн хавсралт



“Элэгний вирусгүй хамт олон” аяны тугийг албан байгууллага, аж ахуй нэгжээр аялуулж, “Элэгний вирусын шалтгаант өвчлөл”, “Амьдралын буруу хэв дадал” сэдэвт сургалт явуулах арга хэмжээнд шаардагдах төсөв

№	Хэрэгжүүлэх арга хэмжээ	Тоо ширхэг	Нэгжийн үнэ	Нийт
1	“Элэгний вирусын шалтгаант өвчлөл”, “Амьдралын буруу хэв дадал” сэдэвт сургалт явуулах	160 цаг	5000	800 000
2	Элэгний вирусын шалтгаант өвчлөл, түүнээс сэргийлэх талаар 4 төрлийн гарын авлагаар хангах	8000	150	1 200 000
3	Нийт			2 000 000